



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/438

Мандалговь

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шинэ
жилийн арга хэмжээнд дэмжлэг
үзүүлэх тухай

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, Засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 318 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Шинэ жилийн баярын өдрийг тохиолдуулан аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шинэ жилийн арга хэмжээнд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Арга хэмжээнд зориулсан дэмжлэгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шинэ жилийн арга хэмжээнд шаардагдах 500000 (Таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191251

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн 430 дугаар
захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бэлэг	25	20000	500000
НИЙТ ДҮН				500000